

# Living the Lotus

Buddhism in Everyday Life

8

2024


VOL. 227



«Цагаан Лянхуа судар ба доктор Скэранжило Доминик»

Хойд Америкийн лидерийн сургалт

Доктор Скэранжило Доминик нь «Лянхуан Гурамсан Сударын орчин үеийн тайлбар» номыг англи хэл рүү шинээр орчуулсан гаргасан болно.



Living the Lotus  
Vol. 227 (2024.08)

Ахлах редактор: Акагава Кэйичи  
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Т.Оюу-Эрдэнэ  
Эхийг хянасан: Ш.Зоригмаа  
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс  
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada,  
Suginami-ku, Tokyo 166-8537 Japan  
TEL: +81-3-5341-1124  
FAX: +81-3-5341-1224  
Email: living.the.lotus.rk-international@  
kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганума Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд) хэмээх тус сэтгүүлийн нэрэнд Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг туулцаая гэсэн хүсэл шингэсэн билээ. Энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

## Бид “эх нутаг” руугаа буцна

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч  
Нивано Ничикоо



### Үүсгэн байгуулагч нирваанд орох үед

Бурхны шашны үзэл санааг дамжуулдаг хамгийн эртний судар гэгддэг “Сутганипата” дахь “Тариан талбайг боловсруулах Барадважа” гэх сэдэвт Шагжамүни бурхан бярмануудад хандан өгүүлсэн шүлэг байдаг ба би «Бодь сэтгэлээ хөгжүүлэх» номондоо түүнийг танилцуулсан. Энэ жил тэр шүлгэнд тулгуурлан хэрхэн бурхны үйлд шамдаж, ямар хандлагатай байх талаар эргэцүүлэн, сар бүрийн сургаалдаа тусгаж байгаа билээ. Тус шүлгийн төгсгөлд “Энэ мэт боловсруулах аваас үхэшгүй мөнхийн үр шимийг хүртэнэ.” гэсэн байдаг. Энэ хэсэг дээр ирээд би өнгөрсөн сард хүний амь насны утга учрын талаар өгүүлж, төгсгөлд нь “үхэшгүй мөнх” гэж ямар утгатай болох талаар та бүхнээс асуусан. Ингээд үхлийн талаарх өөрийнхөө бодлыг шулуухан хуваалцъя гэж бодож байна. Гэхдээ түүний өмнө Үүсгэн байгуулагчийн амьсгал хураасан мөчийн талаар дурдъя.

1999 оны 10-р сарын 4-ны өдрийн өглөөний 10 цаг 34 минутад аав минь болох тус нийгэмлэгийн үүсгэн байгуулагч Нивано Ничикоогийн амьдралын замнал төгссөн билээ. Ах дүүс, садан төрлийнхөн маань Үүсгэн байгуулагчийн орыг тойрон зогсоцгоож, байгууллагын хүмүүс үл ялиг холоос харан залбирах ахуйд тэрээр амар амгалан яван одсон. Би сүүлчийн мөч хүртэл нүдээ анин, шаланд шүргэх Үүсгэн байгуулагчийн баруун гарыг атган суусан. Тэрээр анисан нүдээ том гэгч нь нээгээд яг л хүн бүртэй салах ёс гүйцэтгэж буй мэт орыг нь тойрон хүрээлэх биднийг алгуурхан тойруулан хараад дахин нүдээ аних тэр мөчид амьсгал хураасан юм.



## “Үхэшгүй мөнх” гэдэг нь

Эх нутаг минь  
Тэр бол миний ирсэн газар  
Эх нутаг минь  
Тэр бол миний буцах газар  
“Сурган хүмүүжүүлэгч Тоои Ёшио”

Энэ бол миний эртнээс унших дуртай шүлэг. Бидний амь нас өнгөрсөн цаг үеэс холын хол ирээдүй рүү зогсолтгүй урсах их гол мөрөн мэт “агуу амь” хэмээх “эх нутаг” руугаа буцан оддог гэж би өмнөх сард өгүүлсэн. Ингэж хүлээж авах юм бол үхлийн айдас түгшүүр багасах болов уу.

Миний тухайд гэвэл амар амгалан амь насныхаа эх нутаг руу буцах Үүсгэн байгуулагчийг дэргэдээс нь харснаар “Амьдралын маань эцсийн мөч ийм байгаасай” гэж үхлийг уужуу тайван хүлээж авч чаддаг болсон мэт санагдана. Миний хувьд үхлийн төгс хувилбар мэт санагдах Үүсгэн байгуулагчийн эцсийн мөчийн энэ дүр зураг үхлийн айдас түгшүүрээс ангижрах гэсэн утгатай “үхэшгүй мөнхийн үр шим”-ийг надад хүртээсэн билээ.

“Үхэшгүй мөнх” гэдэг нь үхэхгүй гэсэн үг биш. Мөнх амьдрах юмсан гэсэн хэзээ ч биелэхгүй хий хоосон хүсэл шуналаас улбаатай зовлон шаналалаас ангижирч, сэтгэл санаа амар амгалан болохыг “үхэшгүй мөнх” гэх ба би бол үүнийг “үхэшгүй мөнхийн үр шим” гэж ойлгож байгаа.

Бид бурхны сургаалд суралцсанаар “үхэшгүй мөнхийн үр шим”-ийг хүртэх боломжтой. Түүний нэг арга бол мөнх бусын сургаалыг сэтгэлдээ тунгаан үхлийг даван туулах юм. Өөрөөр хэлбэл үхэл ч гэсэн үүсэн бий болж, устан үгүй болон хувиран өөрчлөгдөх байгалийн үзэгдлийн нэг гэж хүлээж авах явдал. Мөн Лянхуа сударт айлддаг “Бурхан мөнх амьтай” гэх сургаалыг ухааран ойлгох юм бол хүн өөрөө бурханлаг мөн чанарын илрэл тул амьсгал хураасан ч гэсэн дараа нь Бурханы “агуу амь”-тай нэгдэн үүрд мөнх амьдрах юм байна гэсэн сэтгэлийн амар амгаланг олно. Мөн Дармапада сударт “Хичээл зүтгэл нь үхэшгүй мөнх” гэж сургажээ. Энэ нь жижигхэн зүйлийг ч орхигдуулалгүй хичээсэн өдөр тутмын хичээл зүтгэл нь “Түмэн зүйлтэй шүтэн барилдаж, нөлөө нь хэмжээ хязгааргүй тэлэх ба үгүй болно гэж байхгүй” гэсэн утгатай. (Накамүра Гэн)

Бодисадвагийн үйл гээд бидний өдөр тутамдаа хийдэг үйлүүд нь цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хаа сайгүй нөлөөгөө үлдээдэг гэсэн үг. Тийм амьдралын замнал, зан чанар хүмүүсийн сэтгэл зүрхэнд хэзээд дуурсагдан оршдог. Энэ ч гэсэн “үхэшгүй мөнх”-ийн нэг хэлбэр буй за.

Түмэн зүйлийн ач буянаар Шагжамүни бурхнаас 6 илүү насыг зооглоод байгаа миний хувьд Үүсгэн байгуулагчийн нирваанд орсон мөч, “үхэшгүй мөнхийн үр шим”-ийн амтыг мэдрэх ахуйд ингэж бодогдож байна. “Эх нутагтаа хэзээ ч буцсан яах вэ” гэж сэтгэл тайван хэлж чадаж байгаа нь ямар их аз жаргал вэ.

“Косей”сэтгүүл, 8 сарын дугаараас



# Рисшо Косей Кай байгууллага (Зурагт ном)

## Шинэхэн гишүүн танаа

### Жижүүрийн үүргээр дамжуулан өөрийгөө сайжруулах нь

Их ариун ордон, нийгэмлэг дээр бурханд гүнцэг өргөх, үүдэнд сүсэгтэн олныг хүлээн авч мэндлэх, цэвэрлэгээ хийх зэргийг “Жижүүрийн үүрэг” гэж нэрлэдэг.

Үүнийг бүгд хэн нэгнээр хэлүүлж хийх биш харин өөрийгөө сайжруулахын тулд дуртайяа хийдэг. Үүдэнд гишүүдтэй алга хавсран

мэндлэх нь тэдэнд хүндэтгэл үзүүлж буй хэрэг. Цэвэрлэгээ хийх нь сэтгэлийнхээ хар барааныг хөөн зайлуулах бясалгал юм.

Ямар ч үйл байсан “хийж өгөх” биш харин “талархан хийх, бусдын ачаар хийж байна” гэсэн сэтгэлээр хийхийг чухалчилдаг.



#### Бяцхан мэдлэг

Рисшо Косей Кай нийгэмлэгт “бусдад талархан хийнэ” гэж их хэлдэг. Энэ нь жижүүрийн үүргийг даруу төлөв сэтгэлээр хийх гэсэн утгыг агуулдаг ба “Бурхан багш, бусад хүмүүсийг хүндэлж бардам зангүй, даруу төлөв байх болно” гэсэн сэтгэлийг илэрхийлдэг.

\* Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.



## Байгаль дэлхийдээ ээлтэй амьдарцгаая



Таныг “Дэлхийн дулаарал” гэдэг үгийг сонссон гэдэгт итгэлтэй байна. Хүн төрөлхтөн байгаль дэлхийгээ үл анхаарч, ая тухтай амьдралыг эрэлхийлэн амьдарч ирсний уршгаар агаар мандлын дулаарал нэмэгдсээр байна. Нэгэнт бид эх дэлхийн хайр хишгийг хүртэж байгаа учраас байгаль орчноо эрхэмлэн хайрлан хамгаалах учиртай.

Бурхан багш амьтны амийг тасалж, аливаа зүйлийг дэмий гарздахгүй байхыг сургадаг. Дахиад хэрэглэж болохуйц харандаа, дэвтрийг хаях нь мод түүхий эдийг гамгүй хэрэглэж байгаа үйлдэл.

Энэ бол хүн нэг бүрийн тунгааж үзэх ёстой асуудал юм.



### Бяцхан мэдлэг

Агаар сэрүүцүүлэгч болон халаагч төхөөрөмжийг тогтмол нэг температурт байхаар тохируулах, зурагт үзэх цагаа багасгах, дэлгүүрийн тороо өөрөө авч очих, цахилгаан хэрэгслийн цахилгаан тэжээлийг салгах, ваннад орсон усаа угаалганд ашиглах зэргээр дэлхийн дулаарлыг бууруулах үйлдлийг яг одооноос хийж эхэлцгээе.

## Онцгой нэгэн өдөр

Акагава Кэйичи

Японд зуны халуун өдрүүд үргэлжилсээр байна. Та бүхэн амгалан сайн байцгаана уу?

Ерөнхийлөгч энэ сарын айлдвартаа Үүсгэн байгуулагчийн сүүлчийн мөчийн талаар дэлгэрэнгүй өгүүлжээ.

1999 оны 10 сарын 4-ний тэрхүү өдрийг 25 жилийн дараа ч гэсэн би тод санаж байна. Тэрбээр 10 цаг 34 минутад нирваанд орсон тухай мэдээ тэр даруй сүм даяар тархав. Тухайн үед Фүмон танхим дахь Дэлхийн шашинтнуудын энхтайвны чуулгын японы хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж байсан би сэтгэлдээ чимээгүйхэн залбирч байсан ч ойрын харилцаатай байгууллагын холбогдох хүмүүст энэ мэдээг хүргэхээр амьсгалах ч сөхөөгүй ачаалалтай ажиллаж байлаа.

Тэр өдрийн орой би Киотогоос эмгэнэл илэрхийлэхээр ирсэн буддын Тяньтай урсгалын тэргүүн ламыг дагалдан Үүсгэн байгуулагчийн гэр рүү явах чухал үүргийг хүлээсэн юм. Токио буудлаас тосч аваад таксид суун 6 цаг өнгөрч нар шингэж харанхуй болж байхад гэрт нь ирлээ.

Эмгэнэл илэрхийлэхээр ирсэн хүмүүсээр дүүрэн гэрт Үүсгэн байгуулагчийн бүх биеийг харж болохоор тунгалаг шилэн тагтай авс байрлуулсан байсан. Үүсгэн байгуулагч нөгөө л танил хүрмэн дээрээ бүчээ зүүсэн байдалтайгаар яг л амьд сэрүүн үеийнх шигээ тайван дөлгөөнөөр зочин бүртэй алгаа хавсран мэндэлж байгаа мэт дүр төрх нь миний зүрх сэтгэлд тод үлджээ.

“Хүний амьд ахуйдаа туулсан амьдралын замнал, хүн чанар нь хүмүүсийн зүрх сэтгэлд хадгалагдан үлдэх нь үхэшгүй мөнхийн нэг хэлбэр” гэж ерөнхийлөгч айлдсан. Би ч бас Үүсгэн байгуулагчийн нэгэн адилаар хувь тохиолоор учирсан бүх хүмүүсийг уужуу сэтгэлээр хүндлэн мөргөж өдөр бүрийг өнгөрөөхийг хүсэж байна.




Гакүрин сургуулийн гадаад оюутны ангийн элсэлийн ёслол  
2024.04.06

# Rissho Kosei-kai International

Make Every Encounter Matter



## 🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about local Dharma centers



facebook



X



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: [living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp](mailto:living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp)